



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 439

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн 6,399,599,406.00 (зургаан тэрбум гурван зуун ерэн есөн сая таван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001452

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
№ 9 дугаар тогтоолын хавсралт



**"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Гэрээний гүйцэтгэлийн дүн	Зээлийн хүүгийн зардал	Нийт балансын үнэ
		(төгрөг)		
1	18,2 км цахилгаан дамжуулах агаарын шугам	5,377,525,212.00	1,022,074,194.00	6,128,281,722.00
2	Дэд станц (110/35/10кв)			271,317,684.00
НИЙТ ДҮН				6,399,599,406.00
				(зургаан тэрбум гурван зуун ерэн есөн сая таван зуун ерэн есөн мянга дөрвөн зуун зургаан)